



**ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН  
ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДАД  
ЗОРИУЛСАН  
ЦАХИМ СУРГАЛТ**

2022 оны 11-р сарын 30

## НЭЭЛТ

Санхүүгийн бодлогын  
газрын дарга  
**Б.Сүх-Очир**

# 3

### БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АНХААРАХ АСУУДЛУУД

/Худалдан авах ажиллагааны бодлогын  
хэлтсийн ахлах шинжээч **Л.Амгалан/**

# 4

### ТӨК-ийн ШИНЭЧЛЭЛ: НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

/Татварын бодлогын газрын зөвлөх  
**Н.Эрдэнэ/**

# 2

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛТ

/Нягтлан бодох бүртгэлийн бодлогын  
газрын дарга **Б.Болормаа/**

# 5

### БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ

/Санхүүгийн хяналт, шалгалтын  
хэлтсийн дарга **Ж.Цогтбаяр/**



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ГАЗАР

**ТӨК-ИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА,  
ЦААШИД БАРИМТЛАХ БОДЛОГО**

# ЗАСГИЙН ГАЗРЫН ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЗЭЭЛ



Гадаад талдаа хийх эргэн төлөлтийг



Төсвөөс хугацаанд нь төлдөх үүрэгтэй



- Төрийн өмчит компани нь бие даан гадаад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр бүрдүүлж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжгүй байдаг.


- Засгийн газар төрийн өмчит компаниудаа төлөөлөн зээллэгийн гэрээ байгуулах нь гадаад талдаа зээл эргэн төлөгдөх баталгаа болдог бөгөөд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр бүрдүүлэх боломжтой.

- Засгийн газар нь дамжуулан зээлийн эргэн төлөлтийн орлогоор Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлээ төлөхөөр тооцдог. **Харин дамжуулан зээлийн эргэн төлөлт хангалтгүй байх нь улсын төсвийн алдагдлыг нэмэгдүүлдэг.**

# ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИД ОЛГОСОН ДАМЖУУЛАН ЗЭЭЛ

Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгөөр төрийн өмчийн **22** компанид нийт **34** төсөл, хөтөлбөрийн хүрээнд **640.0** сая ам.долларыг дамжуулан зээлдүүлсэн байна. Үүнээс **хэрэгжиж байгаа 5** төсөл, **хэрэгжиж дууссан 29** төсөл байна.

**Зээл авсан компанийн тоо**  
/салбараар/




**Төрийн өмчит компанид олгосон дамжуулан зээл**  
/салбараар/



# ДАМЖУУЛАН ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ УЛСЫН ТӨСВИЙН АЛДАГДАЛД ШУУД НӨЛӨӨЛЖ БАЙНА

## ТӨК-ийн ДАМЖУУЛАН ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ: ТӨЛӨВЛӨГӨӨ vs ГҮЙЦЭТГЭЛ

тэрбум ₮



□ Тухайн онд төлөгдөх ёстой хуваарь ■ Бодит гүйцэтгэл Гүйцэтгэлийн хувь

# ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ

## ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Өрийн  
удирдлагын тухай  
хууль

Иргэний  
хууль

Засгийн газрын гадаад  
зээллэгийн хөрөнгийн  
дамжуулан зээлдүүлэх  
журам

## ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ

Өрийн удирдлагын тухай хуулийн  
32.6.2:

Холбогдох данснаас авлага барагдуулах  
хэмжээний хөрөнгийг суутган авах

Арилжааны банкин дахь данс хаалгах

Бусад байгууллагаас авах авлагаас  
суутган тооцох

Шүүхэд хандах



# ЗЭЭЛИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛЖҮҮЛНЭ



ДЗ-ийн эх  
үүсвэрээр бий  
болсон хөрөнгийн  
бүртгэл

Гадаад зээлийн эх  
үүсвэрээр бий  
болсон хөрөнгийн  
бүртгэл

Тусгай сангийн эх  
үүсвэрээр бий  
болсон хөрөнгийн  
бүртгэл

Улсын төсөв, ЗГ-ын  
дотоод үнэт цаасны эх  
үүсвэрээр бий болсон  
хөрөнгийн бүртгэл



Энэ ажлын хүрээнд дамжуулан зээл авсан байгууллагуудад  
**АЛБАН БИЧИГ** хүргүүлнэ.



## ЗОРИЛГО

# ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨРИЙН СТАТИСТИК НЭГТГЭН ГАРГАХ



## ХУУЛЬ, ТОГТООМЖ

- ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН 39.4 ДЭХ ЗААЛТЫН ДАГУУ ТӨХК-НЫ ӨРИЙН МЭДЭЭЛЛИЙГ ӨРИЙН НЭГДСЭН САНД ОРУУЛЖ ХӨТЛӨХ;



## ИЛ, ТОД БАЙДАЛ

- ОУВС-ИЙН УЛСЫН СЕКТОРЫН ӨРИЙН СТАТИСТИК ГАРГАХ СТАНДАРТЫН ХҮРЭЭНД УЛИРАЛ БҮР ЭСВЭЛ ХАГАС ЖИЛ ТУТАМД ӨРИЙН НЭГТГЭСЭН СТАТИСТИК БЭЛТГЭН НИЙТЛЭХ;



## ӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, СТРАТЕГИ

- ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2023-2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГТ УЛСЫН СЕКТОРЫН ӨРИЙН СТАТИСТИК БЭЛТГЭН ГАРГАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХААР ТУСГАСАН;

# ОУВС-ЫН ӨРИЙН СТАТИСТИК ГАРГАХ БОЛОМЖИТ ХУВИЛБАР



ОУВС-ийн аргачлалын дагуу Улсын секторын өрийг Засгийн газрын өр болон санхүүгийн бус салбарын улсын секторын байгууллагын өрийн нийлбэрээр гаргадаг.

Энэхүү статистикийг тогтмол гаргаснаар олон улсын хөрөнгө оруулагчид болон зээлдүүлэгч байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангахад гол үүргийг гүйцэтгэнэ.

Улсын секторын өрийг гаргахад шаардлагатай Засгийн газрын өр тодорхой байдаг бол төрийн өмчит байгууллагуудын өр болон улсын байгууллагаас авсан өр төлбөрийн мэдээллийг байгууллага тус бүрээс авах хэрэгцээтэй болдог.

**Иймд e-balance системд шинээр оруулж буй дараах загварын дагуу мэдээллийг тогтмол ирүүлэхийг хүсье.**

№	ОР, АВЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	Гадаад өр төлбөр	Дотоод өр төлбөр	Нийт	Тайлбар*
<b>Нийт өр төлбөр (1+2)</b>					
<b>1</b>	<b>Богино хугацаат, болон урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл</b>				
<b>1.1</b>	<b>Төрийн, орон нутгийн өмч /50 болон түүнээс дээш/-ийн оролцоотой аж ахуй нэгжид өгөх өр төлбөр</b>				
1.1.1	Зээл				
1.1.2	Үнэт цаас				
1.1.3	Урьдчилж олсон орлого				
1.1.4	Бүтээгдэхүүн, үйлчилгээ урьдчилан борлуулах гэрээгээр хүлээсэн өр төлбөр				
1.1.5	Охин эсхүл толгой компанид өгөх өр төлбөр				
1.1.6	Бусад				
<b>1.2</b>	<b>Улсын болон орон нутгийн төсөвт өгөх өглөг</b>				
1.2.1	Улсын төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй олгосон төсвийн зээл				
1.2.2	Эрүүл мэндийн даатгал, НДШ-ийн өглөг				
1.2.3	Татварын өглөг				
1.2.4	Ноогдол ашгийн өглөг				
1.2.5	ЗГ-ын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн өрийн үлдэгдэл				
1.2.6	Бусад				
<b>1.3</b>	<b>Хувийн секторт өгөх өр төлбөрийн үлдэгдэл</b>				
1.3.1	Зээл				
1.3.2	Үнэт цаас				
1.3.3	Урьдчилж олсон орлого				
1.3.4	Бүтээгдэхүүн, үйлчилгээ урьдчилан борлуулах гэрээгээр хүлээсэн өр төлбөр				
1.3.5	Охин эсхүл толгой компанид өгөх өр төлбөр				
1.3.6	Бусад				



### Төрийн, орон нутгийн өмч /50 болон түүнээс дээш/-ийн оролцоотой аж ахуй нэгжид өгөх өр төлбөр

- ✓ Урт хугацаат болон богино хугацаат зээл: **Гадаад болон дотоодын байууллагаас авсан бүх төрлийн зээл багтана.**
- ✓ Үнэт цаас
- ✓ Урьдчилж олсон орлого
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээ урьдчилан борлуулах гэрээгээр хүлээсэн өр төлбөр
- ✓ Охин эсхүл толгой компанид өгөх өр төлбөр
- ✓ Бусад бүх өр төлбөр багтана



### Улсын болон орон нутгийн төсөвт өгөх өглөг

- ✓ Улсын төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй олгосон төсвийн зээл
- ✓ Эрүүл мэндийн даатгал, НДШ-ийн өглөг
- ✓ Татварын өглөг
- ✓ Ноогдол ашгийн өглөг
- ✓ ЗГ-ын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн өрийн үлдэгдэл
- ✓ Бусад



### Хувийн секторт өгөх өр төлбөрийн үлдэгдэл

- ✓ Урт хугацаат болон богино хугацаат зээл: **Гадаад болон дотоодын байууллагаас авсан бүх төрлийн зээл багтана.**
- ✓ Үнэт цаас
- ✓ Урьдчилж олсон орлого
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээ урьдчилан борлуулах гэрээгээр хүлээсэн өр төлбөр
- ✓ Охин эсхүл толгой компанид өгөх өр төлбөр
- ✓ Бусад

# ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН АВАХ УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

## Байгууллагын шалгуур, шаардагдах мэдээлэл

### Мэдээлэл

- Хуулийн этгээдийн компанийн засаглалыг нөхцөл байдал, дүрэм, үйл ажиллагааны тайлан;
- Зээллэг хийх талаар гарсан удирдлага болон төрийн эрх барих байгууллагуудын шийдвэр;
- Бусад этгээдэд барьцаалсан хөрөнгө;
- Улсын болон орон нутгийн төсвөөс төлж болзошгүй өр төлбөр болон татаас, урсгал зардлын тооцоолол;
- Зээллэгийн нөхцөл, түүнийг эргүүлэн төлөх төлөвлөгөө буюу санхүүгийн мөнгөн урсгалын төсөөлөл;
- Төслийн тарифын талаар мэдээлэл, таамаглал, түүний тайлбар;
- Санхүүгийн болон үйл ажиллагаа, зах зээлийн эрсдэл, түүний тайлбар;
- Гэрээгээр хүлээсэн өр төлбөрийн үүрэг, түүний биелэлт;
- Төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ;
- Төсөл, арга хэмжээний үр ашиг, өгөөж, эргэн төлөгдөх чадвар, хэрэгжих үндэслэл.

### Ерөнхий шалгуур

- Зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартайг нотолсон байх;
- Улсын болон орон нутгийн төсөвт хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх;
- Зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тодорхой хувийг Монголын талаас хөрөнгө оруулах төсөл хэрэгжүүлэгч нь хөрөнгө оруулах чадвартайг нотолсон байх;
- Зээллэгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангах.

## Хэрэгцээ шаардлага

Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн өр

Төсвийн тухай хуулийн  
52 дугаар зүйл

Засгийн газрын болзошгүй өр төлбөр  
(Хэрэв төлж чадахгүйд хүрвэл кросс дефолт болох эрсдэлтэй)

Төрийн болон орон  
нутгийн өмчийн тухай  
хууль 21.16

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө, өр  
төлбөрийн зохистой удирдлагад хяналт тавих, Засгийн  
газрын болзошгүй өр төлбөрөөс сэргийлэх

**Зөвшөөрөлгүй он дамжсан өр үүсгэхгүй байх, улсын болон орон нутгийн төсөвт төлөх өр төлбөрийг төлж барагдуулах**



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ГАЗАР

# ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, АНХААРАХ АСУУДЛУУД

## АГУУЛГА

- **ЗАХИАЛАГЧ, ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ, ХУУЛЬД ОРСОН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ /2022 он/**
- **ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ**
- **ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АНХААРАХ АСУУДЛУУД**



## Захиалагч гэж хэн бэ?

- төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;
- 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч.



## ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна:

- үнэлгээний хороо байгуулах;
- үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах;
- үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах;
- худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;
- энэ хуулийн 7.6-д зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх;
- гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах; 46.1.7.хууль, гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулахгүй байх;
- барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;
- ✓ Энэ хуулийн 4.1.1-д заасан захиалагчийг төлөөлж төсвийн ерөнхий менежер, 4.1.2-т заасан захиалагчийг төлөөлж гүйцэтгэх захирал энэ хуулийн 46.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.



**ТӨРИЙН БОЛОН ОРОН  
НУТГИЙН ӨМЧИЙН  
ХӨРӨНГӨӨР БАРАА,  
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ  
ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН НЭМЭЛТ  
ӨӨРЧЛӨЛТ**

**1**

**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ  
ОНЦГОЙ ЖУРМААР ЗОХИОН  
БАЙГУУЛАХ**


**2**

**ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДЫН  
САНХҮҮГИЙН ДАРАМТЫГ  
БУУРУУЛЖ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН  
УРСГАЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ**

**3**

**ШУУРХАЙ ТЕНДЕР  
ШАЛГАРУУЛАЛТ**


## ТЕНДЕРИЙН БАТАЛГАА



Тендерт оролцогчоос гаргах тендерийн баталгаа 4 дахин буурсан.

**20.4. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг төсөвт өртгийн 0.5 хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.**

## ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА



**Санхүүжүүлэх дүнгээр жил бүр шинэчлэн гаргах**

43.2. Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.

43.8.Төсвийн жил дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааны хугацаа дуусахаас өмнө захиалагчид гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлнэ.

43.9.Гүйцэтгэгч энэ хуулийн 43.8-д заасан гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол түүнийг гэрээний үүргээ зөрчсөнд тооцож, гүйцэтгэлийн баталгааг орлого болгоно.



**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГА ӨӨРИЙН ХЭРЭГЦЭЭНД  
ХУДАЛДАН АВАХ БОЛОН ТУХАЙН  
ОРОН НУТАГТ ХУДАЛДАН АВАХ  
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХУВЬД ЗАХИАЛАГЧ БАЙХААР  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН.**

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА НЬ ШААРДЛАГАТАЙ ГЭЖ ҮЗВЭЛ СУМ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ЭНЭ ХУУЛИЙН 45.2.2-Т ЗААСАН ЭРХЭЭ ШИЛЖҮҮЛЭ БОЛНО.

## НЭМЭЛТ АЖИЛД ГЭРЭЭ БАЙГУУЛАХ



Анхны гэрээний 15%-аас хэтрээгүй нэмэлт ажилд гэрээ шууд байгуулна.

**34.1.4. нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол**

# ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭГ БОГИНО ХУГАЦААНД ХИЙНЭ



ЗАХИАЛАГЧ ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭГ 30 ХОНОГТ  
БАГТААН ХИЙДЭГ БАЙСНЫГ БАГАСГАЖ АЖЛЫН  
15 ӨДӨРТ БАГТААН ХИЙНЭ.

# **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ**

**Шинэчилсэн найруулгын танилцуулга**





МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6, 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хэрэгжүүлэх ажиллагаанд мөрдөж ажиллахыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан захиалагч нарт даалгасугай.

3. Батлагдсан журмын дагуу захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланд хяналт тавьж, шинжилгээ үнэлгээ хийж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Наранцогт/, Хууль, эрх зүйн газар /З.Энхболд/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаал, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Б.ЖАВХЛАН

- ❖ Сангийн сайдын 2021.06.30-ны өдрийн 102 дугаар тушаалын хавсралтаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг шинэчлэн баталсан.
- ❖ Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд 2021.07.20-ны 5384 дугаарт бүртгэгдсэн.
- ❖ Журам нь 5 зүйл, 39 заалт, 13 дэд заалт, хавсралт 5 маягтаас тус тус бүрдэнэ.



## ЖУРМЫН ЗОРИЛГО:

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу захиалагч **төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, өөрийн хөрөнгө, зээл, тусламж, хандивын хөрөнгө, бусад эх үүсвэрээр** тухайн төсвийн жилд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах болон захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтад хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад журмын зорилго оршино.

## ЖУРМЫН БҮТЭЦ

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Төлөвлөгөө, тайланг хүргүүлэх үе шат

Гурав. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт

Дөрөв. Худалдан авах ажиллагааны тайлагналт

Тав. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, шинжилгээ, үнэлгээ хийх, нэгтгэн дүгнэх

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИНЭЧЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ЖУРМЫГ БОЛОВСРУУЛСАН.



Санхүүжилтийн бүх эх үүсвэрээр хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах асуудлыг тодорхой заасан;



Захиалагч, түүний дээд шатны байгууллага хоорондын төлөвлөх, тайлагнах харилцааг нарийвчлан зохицуулсан;



Захиалагч бүрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт тавьж, шинжилгээ үнэлгээ хийхээр тусгасан;

### Журмын гол шинэчлэл

Төлөвлөх, тайлагнах ажиллагааг цахим системээр бүрэн гүйцэтгэх боломжийг бий болгож, худалдан авах ажиллагааг жилд нэг удаа тайлагнахаар заасан;



Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тайлагнах ажиллагаанд тусгасан;



Төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах ажиллагааг захиалагч, дээд шатны байгууллага хариуцахаар тусгаж, төлөвлөгөө хянан батлах шат дамжлагыг бууруулсан.



## ТӨЛӨВЛӨХ:

- Төсөв батлагдсан даруйд захиалагч төлөвлөгөөг боловсруулж батлах;
- Дээд шатны байгууллага захиалагчийн төлөвлөгөөг хянан баталж, Сангийн яаманд төсөв батлагдсанаас хойш **ажлын 10 хоногийн дотор** илгээх;
- Сангийн яам төлөвлөгөөг батлах.

## ХЭРЭГЖҮҮЛЭХ:

- Төлөвлөгөөнд заасан тендер зарлах хугацааг баримтлах;
- Захиалагчийн баталсан төлөвлөгөөний өөрчлөлтийг дээд шатны байгууллага хянан, батлах;
- Төлөвлөгөөг зохих ёсоор хэрэгжүүлэх.

## ХЯНАХ, ҮНЭЛЭХ:

- Сангийн яам захиалагчийн жилийн эцсийн тайлангийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ өгөх;
- Захиалагчийн үнэлгээг нэгтгэн дээд шатны байгууллагын худалдан авах ажиллагааг нэгтгэж дүгнэж, Засгийн газарт дараа жилийн эхний улиралд тайлагнах.


## ТАЙЛАГНАХ:

- Захиалагч тайланг **12 дугаар сарын 1-ний дотор** дээд шатны байгууллагад илгээх;
- Дээд шатны байгууллага захиалагчийн тайланг хянан баталж, Сангийн яаманд **1 дүгээр сарын 15-ны дотор** илгээх.



Төсөв батлагдсан даруйд төлөвлөгөө боловсруулж, батална.

Ажлын 10 хоног



## БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ:

- ✓ Тухайн жилийн төсөвт тодотгол хийсэн, хуульд заасан бусад эх үүсвэр батлагдсан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар төсөвт зохицуулалт хийсэн;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол, хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл үүссэн.

**ЗАХИАЛАГЧ**



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,  
ХОЛБОГДОХ БУСАД ЭТГЭЭД**

Төлөвлөгөөний  
нэмэлт, өөрчлөлт нь  
батлагдсан нийт  
төсөвт өртгөөс  
нэмэгдсэн бол

**САНГИЙН ЯАМ**

хянан, цахим  
системээр  
баталгаажуулна.



**Сангийн яам тайланг  
нэгтгэн дүгнэж,  
дараа жилийн эхний  
улиралд Засгийн  
газарт тайлагнана.**

-Батлагдсан төлөвлөгөөг цахим системээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаг хугацаанд нь ирүүлсэн эсэх;

-Тайланг цахим системээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаг хугацаанд нь ирүүлсэн эсэх;

-Төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагаанд холбогдох журам, аргыг баримталсан эсэх;

-Төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер зарласан эсэх;

-Тендерийн урилгыг цахим системд нийтэлсэн эсэх;

-Тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулах, татгалзах, шалгараагүй талаар мэдэгдэл хүргүүлсэн эсэх;

-Тендер шалгаруулалтын үр дүнг шийдвэр гарсан өдөр цахим системд нийтэлсэн эсэх;

-Гэрээ байгуулах эрх олгогдсон тендерт оролцогчийн тендерийг бусад оролцогчид холбогдох журамд заасан хугацаанд ил болгосон эсэх;

-Тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулсан эсэх;

-Гэрээний мэдээллийг цахим системд нийтэлсэн эсэх;

-Гэрээ байгуулах эрх олгосон асуудлаар гарсан гомдол захиалагчийн талд шийдвэрлэгдсэн эсэх.

# АНХААРАХ АСУУДАЛ

- ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛАХДАА ШИНЭЧЛЭН БАТАЛСАН ЖИШИГ БАРИМТ БИЧГҮҮДЭЭС ТОХИРОХЫГ АШИГЛАХ;
- ШИНЭЭР БАТЛАГДСАН ЖУРАМ, ЗААВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ;
- ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛАХ;
- УЛИРЛЫН ЧАНАРТАЙ ХИЙГДЭХ АЖЛЫГ ТӨСӨВ БАТЛАГДСАН ДАРУЙ ЭХЛҮҮЛЭХ;
- ЦАХИМ СИСТЕМД ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ҮР ДҮН БОЛОН ГЭРЭЭГ ТУХАЙ БҮР ОРУУЛАХ;
- ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮД ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭГ ХУУЛЬ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН, ҮНЭН ЗӨВ ХИЙХ, ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ ЗОХИХ ЁСООР ХИЙХ;
- ҮНЭЛГЭЭ ХИЙХДЭЭ ЦАХИМ СИСТЕМЭЭС ТАТСАН МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭХ;
- ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ;






МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

ТАТВАРЫН БОДЛОГЫН ГАЗАР

**ТӨСВИЙН ОРЛОГО - БОДЛОГЫН  
ШИНЭЧЛЭЛ: ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН  
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДҮҮДИЙН ШИНЭЧЛЭЛ**

## Статистик үзүүлэлт /2021/:



## Харьцуулсан үзүүлэлт /2021/:


### 1. Зардлын талаар:



**Тайлбар:** Санхүүгийн тайланд тусгагдсан зардалд үндэслэв. Хөрөнгө оруулалтын зардал энэ хэсэгт ороогүй болно.



### Хөрөнгийн өгөөж



Монголын топ 100 ААН-ийн ашигт ажиллагааны хувь нь **7.1%**, хөрөнгийн өгөөж нь **5.0%** байна.

Дэлхийн банкны 2021 оны судалгаагаар Монгол Улсын ТӨК-үүдийн хөрөнгийн өгөөж **0.2** байна.



## Санхүүгийн сахилга бат сул, ашигт ажиллагаа бага

Төрийн өмчийн компаниуд, ТӨҮГ-ын өөрийн болон нийт хөрөнгийн өгөөж, ашигт ажиллагаа бага байна.

Хувийн хэвшил үйл ажиллагаа явуулах боломжтой салбарт төрийн өмчит компаниуд оролцож зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлаж



ТӨК-ийн зорилго, үйл ажиллагааны цар хүрээ, мандат тодорхой бус

Дийлэнх төрийн өмчит компаниуд нь хувийн хэвшил хийж чадаагүй орхигдуулсан нийгмийн ямар асуудлыг шийдвэрлэх зорилгоор байгуулагдсан нь тодорхой бус байдаг.




ТУЗ, гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалт, үнэлгээ хаалттай

ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, гэрээг сунгах, ажлын үр дүнг үнэлэх үйл ажиллагаа нээлттэй бус /олон нийтэд хаалттай/.



Мэдээлэл ил тод бус





## ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

**6.4.ТӨРИЙН ӨМЧИТ АЖ  
АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮР  
АШИГ, ЗАСАГЛАЛЫГ  
САЙЖРУУЛЖ, ОЛОН  
НИЙТИЙН ШУУД  
ХЯНАЛТАД ОРУУЛАХ  
АЖЛЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛНА.**



### **БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ШИНЭЧЛЭЛ (ШСБ 6.4.5)**

Төр хувийн хэвшилтэй өрсөлдөж үйл ажиллагаа эрхлэхгүй,  
зөвхөн стратегийн ач холбогдол бүхий салбарт, эдийн засаг, нийгмийг  
хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх  
зорилгоор,

төрөөс үнэ тарифын зохицуулалт хийдэг, хувийн салбар дангаараа  
эрхлэх боломжгүй, нийтийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй эрхлэх  
үйл ажиллагааны чиглэлд компани байгуулдаг байх,  
нээлттэй хувьцаат компани болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх

### **ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛ**

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл  
Засгийн газрын 2021 оны 345 дүгээр тогтоол



### **НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ**

УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоол



### Төрийн мэдэлд 100% байх

- Төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг
- Үнэ, тарифын хяналттай, чөлөөт зах зээлийн зарчмаар тогтдоггүй
- Тухайн салбарт чөлөөт өрсөлдөөн сул, монопол
- Олон улсын гэрээ хэлэлцээрээр, тусгай хуулиар зохицуулдаг

### 34-өөс доошгүй хувийн нэмэлт хувьцаа гарган хөрөнгө оруулалт (IPO) татаж нээлттэй ХК болох

- Төрийн оролцоо шаардлагатай
- Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа
- Санхүүгийн эрсдэл бага
- Үр ашигтай

### Худалдах, татан буулгах, нэгтгэх

- Төрийн ямар нэг чиг үүргийг хэрэгжүүлэхгүй, зорилго, зорилт тодорхойгүй
- Үйл ажиллагааг хувийн хэвшил бие даан гүйцэтгэх боломжтой
- Чиг үүргийг нэгтгэх боломжтой

# ТӨРИЙН МЭДЭЛД 100 ХУВЬ БАЙХ

Төрийн өмчит  
компаниудад **сайн  
засаглалыг бэхжүүлж,**  
үйл ажиллагаа,  
санхүүгийн тайлагналын  
**ил тод байдлыг  
хангана.**

Засгийн газар хоорондын  
хэлэлцээрээр зохицуулагддаг.

1. Улаанбаатар төмөр зам ХНН
2. Монгол Кувейтийн байгаль  
хамгаалах төв ТӨҮГ
3. Монголын газрын тос  
боловсруулах үйлдвэр ХХК
4. Хөшигийн хөндийн нисэх  
онгоцны буудал ХХК

Үнэ, тарифыг төрөөс  
зохицуулдаг этгээд

1. Дулааны цахилгаан станцууд
2. Эрчим хүчний дамжуулах сүлжээнүүд
3. Таван толгой түлш ХХК

Стратегийн орд газрын тусгай  
зөвшөөрөл эзэмшигч этгээд

1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ
2. Монголросцветмет ТӨҮГ
3. Эрдэнэс оюу толгой ХХК

Төрийн бодлого, үндсэн чиг үүргийг  
хэрэгжүүлдэг болон тусгай  
зориулалтын хуулийн этгээдүүд

1. Дипломат байгууллагын үйлчилгээг  
эрхлэх газар ТӨҮГ
2. Барилгын хөгжлийн төв ТӨҮГ
3. Монголын төмөр зам ХК
4. Төрийн орон сууцны корпорац ХХК
5. Монгол Улсын Хөгжлийн банк ХХК
6. Үнэт цаасны хадгаламжийн төв ХХК
7. Монголын үнэт цаасны клирингийн  
төв ХХК
8. МИАТ ХХК

ТӨК-ийн санхүүгийн үйл ажиллагааг үнэлэх, эрсдэл тооцоход ашиглагддаг аргууд:

Z-Score : Edward I. Altman-ий компаний санхүүгийн дарамтыг тооцох модел

S-Score : Gordon Springate-ий компаний санхүүгийн эрсдэл, дампуурах магадлалыг тооцох модел

**S-Score**: Модел нь Altman-ий моделийн шинэчилсэн хувилбар бөгөөд компанийг дампуурах магадлалыг тооцно. Тооцоололд нийт хөрөнгийн хэмжээнд хэт тулгуурлаагүй, сайжруулсан хувилбарыг ашиглалаа.

Z-Score, S-Score нь олон улсын компаниудад ашиглагддаг. үнэлгээний өргөнөөр



**S&P Global**  
Ratings

**EJ** Egan-Jones  
Ratings Company




**Fitch Ratings**  
**MOODY'S**



**S-Score нь 0-ээс  
0.86-ын хооронд  
байгаа 33 компани  
нь санхүүгийн  
эрсдэлтэй,**

**S-Score нь 0-ээс  
бага 47 компани нь  
санхүүгийн өндөр  
эрсдэлтэй байна.**



(санхүүгийн тайлангаа илгээгээгүй 6 ТӨК, Санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 ТӨК тооцоонд оруулаагүй болно)

Хамгийн өндөр эрсдэлтэй нь **Монголын эрдэс баялгийн бирж. Эрдэнэс шивээ энерги ХХК, Дарханы арьс ширний цогцолбор бүтээн байгуулалт ХХК** бол хамгийн бага эрсдэлтэй нь **Архангай-АЗЗА ТӨХК, Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ** байна.



## ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР ДАМЖУУЛАН ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ

1. Үндэсний давхар даатгал ХК
2. Монголын хөрөнгийн бирж ТӨХК
3. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК
4. Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ
5. Монголын цахилгаан холбоо ХК
6. АЗЗА (20 компани)  
**(НИЙТ 25 КОМПАНИ)**

- ❖ “ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВЬЦААГ 2022-2023 ОНД БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолыг баталсан.
- ❖ “ТӨРИЙН МЭДЛИЙН ХУВЬЦААГ 2022-2023 ОНД БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ” Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 243 дугаар тогтоолоор олон нийтэд нээлттэй худалдах хувь, хэрэгжүүлэх хугацааг баталсан.

## НЭГТГЭХ, НИЙЛҮҮЛЭХ

1. Геологийн судалгааны төв ТӨҮГ
2. Геологийн төв лаборатори
3. Үндэсний геологийн алба

1. Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ
2. Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ

1. Цагаан шонхор ТӨҮГ
2. Бөртэ ТӨҮГ


1. Буянт Ухаа спортын ордон
2. Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв

## ЦААШИД ТӨР ОРОЛЦОХ ШААРДЛАГАГҮЙ, САНХҮҮГИЙН ЭРСДЭЛТЭЙ

1. Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ
2. Хөдөө аж ахуйн бирж ХХК
3. Автоимпекс ХК
4. Дарханы арьс ширний цогцолбор бүтээн байгуулалт ХХК
5. Монгол Ус ТӨҮГ
6. Радиотелевизийн үндэсний сүлжээ ТӨҮГ
7. Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨҮГ

- ❖ “ТӨРИЙН ӨМЧИТ ЗАРИМ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 243 дугаар тогтоол,
- ❖ 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд цаашид төр оролцох шаардлагагүй, хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой үйл ажиллагаа эрхэлж буй учраас худалдах, татан буулгах, эсвэл ижил төстэй байгууллагатай нэгтгэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан.

## Зах зээлийн үнэлгээ



- ❖ Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ сүүлийн жилүүдэд байнгын өсөлттэй байгаа ба **2021 онд 97% өссөн** байна.
- ❖ 2021 онд манай улсад IEO (койн) –оор дамжуулж 20 криптовалют **475.4 тэрбум** төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.
- ❖ Хамгийн өндөр хөрөнгө оруулалт татсан токен нь цахилгаан станц барих төслөөрөө **142.5 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалт татсан байна.

Эх сурвалж: lemonpress.mn

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нэмэгдэж, үйл ажиллагаа эрчимжиж, зах зээлд оролцогчид нэмэгдсэн энэ үед төрийн өмчит компаниудын **IPO ХИЙН НЭМЭЛТ ХУВЬЦААГ ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ** оновчтой үе юм.



“Монгол шуудан” ХК-ийн 34 хувийн хяналтын багцыг  
2016 оны 1 сард хөрөнгийн биржээр дамжуулан худалдсан

Монгол шуудан ХК-ийн хувьцааны үнэ



Үзүүлэлт	2015	2021	Зөрүү
Оруулсан хөрөнгийн өгөөж /ROA/	0.006	0.012	2.0x
Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	0.007	0.016	2.3x
Нийт орлого /сая ₮/	9,971.5	19,838.8	2.0x
Цэвэр ашиг /сая ₮/	94.0	400.0	4.3x
Зах зээлийн үнэлгээ /сая ₮/	21,124.2	100,781.4	4.8x



**ТӨК-ИЙН НОГДОЛ  
АШГИЙН БОДЛОГООР  
ДАХИН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТАД  
ЗАРЦУУЛАХ ЭХ  
ҮҮСВЭРИЙН ОРОН  
ЗАЙГ ЗОХИЦУУЛНА**

**Ногдол  
ашгийн  
бодлого**

**Тогтвортой ногдол ашгийн бодлого  
(Stable Dividend Policy)**



- Урт хугацааны ашгийн төлөвлөгөөнөөс тогтмол хэмжээгээр ногдол ашиг олгодог
- Ногдол ашиг нь урт хугацаанд тогтвортой өсөлттэй
- Нээлттэй компаниудын хамгийн түгээмэл жишиг

**Ашгаас тогтмол хувиар ногдол ашиг бодох  
(Constant Dividend Payout Ratio Policy)**



- Цэвэр ашгийн тодорхой тогтсон хувиар ногдол ашиг олгодог
- Богино хугацааны орлогын хэлбэлзлээс хамаарч тогтворгүй байдаг

**Үлдэгдэл ашгаас ногдол ашиг бодох  
(Residual Dividend Policy)**



- Цэвэр ашгаас компанид шаардлагатай дахин хөрөнгө оруулалтыг санхүүжүүлээд үлдэх хэсгийг ногдол ашгаар хуваарилдаг.
- Хөрөнгө оруулалтын хэрэгцээгээ хангаад ашигтай ажилласан үед л ногдол ашиг хуваарилна.



**НОГДОЛ АШИГ  
ТООЦОХ  
ЗОХИЦУУЛАЛТЫГ  
ШИНЭЧИЛСНЭЭР  
ТӨК-ИЙН ЗАРДЛЫГ  
САХИЛГА БАТЫГ  
САЙЖРУУЛНА**



**Ашгаас тогтмол хувиар  
ногдол ашиг бодох**  
(*Constant Dividend Payout Ratio Policy*)

**Цэвэр ашгийн 50%**

## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО



**Тогтвортой ногдол  
ашгийн бодлого**  
(*Stable Dividend Policy*)

**Төрийн өмчид хамаарах  
эздийн өмчөөс 1%**



**Аль өндөр дүнгээр тооцон  
ногдол ашиг бодно.**

**Давуу талууд:**

- Ашиггүй учир ногдол ашиг хуваарилдаггүй, төсөвт өгөөж өгдөггүй байдлыг зогсооно.
- Олон улсын жишигт нийцсэн ногдол ашгийн бодлоготой болно
- Уул уурхайн баялгаас хамаарсан их хэмжээний рентийн орлогыг төр ногдол ашгийн орлогоор төвлөрүүлж захиран зарцуулна.
- Компани бие даан их хэмжээний хэлцэл хийх, хөрөнгө оруулалт хийх асуудлыг ногдол ашгийн бодлогоор зохицуулна.



# Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд тусгасан саналууд:

## 1. Засаглалыг сайжруулах чиглэлээр

- Компанийг үүсгэн байгуулахдаа хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн үр дүнтэй байдал, үйл ажиллагаа явуулах хугацааг тусгасан **төлөвлөгөөг гаргана.**
- Компанийн дүрэмд **үйл ажиллагааг явуулах хугацааг** заасан байна.
- Гүйцэтгэх захирлыг төлөөлөн удирдах зөвлөл сонгож, **нэг жилийн хугацаатай гэрээ байгуулан**, үр дүнгийн гүйцэтгэлийн **үнэлгээг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл тухай бүр сунгана.**
- Компанийг **хоёр жил дараалан алдагдал хүлээлгэсэн**, эсхүл төрөөс оруулсан хөрөнгө оруулалт, гэрээнд заасан санхүүгийн зорилтод **үзүүлэлтийг хоёр жил дараалан хангаж чадахгүй болсон**, бизнесийн төлөвлөгөөний **гүйцэтгэлийн үнэлгээ хоёр жил дараалан хангалтгүй гэж үнэлэгдсэн** тохиолдолд гүйцэтгэх захирлыг **ажлаас нь чөлөөлж, гэрээг цуцална.**

## 2. Санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр

- Зээлийн гэрээний дагуу төлбөл зохих хуваарьт болон **хугацаа хэтэрсэн өр төлбөрийг тухайн жилийн төсөвт бүрэн тусгасан** байна.
- **Ногдол ашгийг хуваарилахдаа** өмнөх жилийн **цэвэр ашгийн тодорхой хувиар** эсвэл төрийн болон орон нутгийн эзэмшлийн **хувь нийлүүлсэн хөрөнгийн тодорхой хувиар** тооцох ба жил бүр ногдол ашгийн нийт дүнгийн доод хэмжээг УИХ-аас төсөвт тусган батална.
- **Нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа** явуулах саналыг Засгийн газраар хэлэлцүүлнэ.
- **Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс** чөлөөлөгдөхөд нөхөн төлбөр, олговор зэрэг аливаа хэлбэрийн **тэтгэмж олгохыг хориглоно.**
- **Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн** энэ хуульд заасан урамшууллаас бусад **тусгайлсан хангамж эдлэхгүй.**



## Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд тусгасан саналууд:

### 3. Ил тод байдлыг сайжруулах чиглэлээр

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нэр дэвшигч тус бүрийн үнэлгээний оноо, сонгон шалгаруулах журам, нэр дэвшигчийн нөөцийн сангийн мэдээллийг төрийн өмчийн асуудал хариуцсан **төрийн захиргааны байгууллага өөрийн цахим хуудаст нээлттэй ил тод байршуулна.**
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг **албан тушаалаар томилохгүй.**
- **Санхүүгийн тайланг** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмыг баримтлан бэлтгэж, **ил тод тайлагнах;**
- **Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч** төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн нэгээс илүү жилийн хугацаанд хэрэгжүүлэх **хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг уул уурхайн болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.**
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллээс гадна компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө; **компанийн дүрэм, компанийн үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журам мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.**

### 4. Хяналтыг сайжруулах чиглэлээр

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, албан тушаалтан ногдол ашгийг нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх; компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, эрсдэлийг бууруулахаас **бусад тохиолдолд оролцож, удирдамж, чиглэл өгөхийг хориглоно.**
- **Төлөөлөн удирдах зөвлөл нь** Компанийн тухай хуулийн 81.4-т заасан чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах чиг үүрэг бүхий **аудитын хороотой байх ба том компаниуд төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дотоод аудитын нэгжтэй байна**





МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЛИЙН  
УДИРДЛАГЫН ГАЗАР

# БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

## АГУУЛГА

### БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

1. ДОТООД ХЯНАЛТ
2. ДОТООД АУДИТ




“Зохих хяналтгүй эрсдэл оршин байвал их муу, мөн эрсдэлд чиглээгүй хяналт байх нь нөөцийг үр дүнгүй зарцуулсантай адил.”

Боб МкДоналд  
Австралийн Аудитын хорооны дарга

---

## Үр дүнтэй эрсдэлийн удирдлага болон хяналтын хамгаалтын 3-н шугам



COSO- дотоод хяналтыг дараах байдлаар тодорхойлсон.



Дотоод хяналт

Байгууллагын үйл  
ажиллагаа зохистой,  
үр ашигтай байх



Дотоод хяналт

Санхүүгийн  
тайлагнал үнэн зөв,  
бодитой байх



Дотоод хяналт

Хууль тогтоомж, дүрэм журмыг  
дагаж мөрдөж хэвшүүлэхэд  
чиглэсэн удирдлагын болон бүх  
шатны менежерүүдийн үйл  
ажиллагаа



**Байгууллагын дотоод хяналт** нь зөвлөгөө өгөх замаар удирдлагад туслахдаа дараах **үндсэн үүргийг** гүйцэтгэнэ:


-Ажил, гүйлгээ гүйцэтгэх горимууд нь зохих ёсоор үр ашигтай хэрэгжиж байгаа эсэх;

-Хууль тогтоомж болон удирдлагын зүгээс тавьсан шаардлагыг мөрдөж байгаа эсэх;

-Тухайн байгууллагын хөрөнгө хамгаалалттай эсэх;

-Бүртгэл нь иж бүрэн, үнэн зөв эсэхийг хянан тогтоож шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

## Дотоод хяналтын бүрэлдэхүүн



## INTERNAL CONTROL FRAMEWORK



Хяналтын орчин



Эрсдэлийн үнэлгээ



Хяналт



Мэдээлэл харилцаа



Мониторинг



байгууллагын хамт олны зүгээс  
хяналтад хандах хандлага



эрсдэлийг тогтоож, шинжлэх,  
удирдах



байгууллагын зорилго, зорилт,  
төсөв, төлөвлөгөө, удирдлагын  
үүрэг даалгавар хэрхэн биелэгдэж  
байгааг хянах ажиллагаа



менежерүүд болон ажилтнууд чиг  
үүргээ хэрэгжүүлэхэд нь  
шаардагдах мэдээллийг  
тохиромжтой хэлбэрээр цаг тухайд  
нь бүрдүүлэх, солилцох



дотоод хяналтын чанарыг  
үнэлэх ажиллагаа

Дотоод хяналтын тогтолцоо:

Байгууллагын ажилтан бүр **дотоод** хяналтад тодорхой хариуцлага хүлээдэг.

Ажилтан бүрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нь **хяналтын** үндэс болдог, тэд дүрэм журам, стандарт, ёс зүй зөрчсөн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой байдаг.

Менежерүүд: гүйцэтгэх захирал салбар нэгжийн захирлууд

Гүйцэтгэх захирал нь байгууллагын хэмжээнд **дотоод хяналтын** үр дүнтэй тогтолцоо, эрүүл, эерэг орчин бүрдүүлж, хэрэгжүүлэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ.

Салбар нэгжийн захирлууд хариуцсан Тодорхой чиглэлээр **хяналтын** тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлнэ, ялангуяа санхүүгийн алба онцгой үүрэг гүйцэтгэнэ.



## ХЯНАЛТЫН АРГА:

Чиг үүргийг тусгаарлах – тухайлбал хөрөнгийг захиран зарцуулах зөвшөөрөл өгдөг, хариуцан хадгалдаг, бүртгэдэг чиг үүрэг тусгаарлагдсан байх

- Ажил гүйлгээг заавал зөвшөөрлөөр гүйцэтгэдэг байх – зөвхөн эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр аливаа ажил гүйлгээг гүйцэтгэдэг байх
- Ажил гүйлгээний баримтыг зохих журмын дагуу хадгалах.
- Аливаа ажиллагаа бүрийг хянадаг журамтай байх
- Аливаа хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих **хяналтын** арга хэрэгсэлтэй байх **хяналтын** камер, нууцлал бүхий цоож г.м
- Төсөв, төлөвлөгөөний биелэлтийг үе үе хянаж, дүн шинжилгээ хийдэг байх

## **Дотоод хяналтын ач холбогдол:**

-Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг системтэйгээр үнэлж, тогтмол хяналт тавьж, байнга сайжруулах нөхцөл бүрдэнэ.

-Байгууллагын эрсдэлийн удирдлага сайжирна. Байгууллагад учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэлээс урьдчилан сэргийлж, аливаа сөрөг нөлөөлөл, хохирлоос өөрийгөө хамгаална.

-Байгууллагын үйлдвэрлэлийн технологийн горим, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанар, аюулгүй байдал хангагдана.

-Хэрэглэгч, үйлчлүүлэгчийн итгэл дээшилж, бизнесийн нэр хүнд нь өснө.

-Нийгмийн хариуцлагатай байгууллага гэж нийгэмд үнэлэгдэж, үнэ цэнэ нь өсч, зах зээлд эзлэх байр суурь нь бэхжиж, ашиг орлого нь нэмэгдэнэ.

## ДОТООД АУДИТ

Дотоод аудит нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгөх ба зөвлөх үйл ажиллагаа юм. Энэ нь системтэй, оновчтой арга хандлагаар байгууллагын эрсдэлийн удирдлага, засаглал ба дотоод хяналтын үйл явцыг үнэлэх ба сайжруулахад тусладаг.



Байгууллагын удирдлагын оновчтой шийдвэр гаргахад зохистой мэдээллийн ач холбогдол асар их бөгөөд энэхүү мэдээлэл нягтлан бодох бүртгэл болон бусад эх үүсвэрээс бий болж, дотоод аудитаар баталгаажиж байдаг.



Эрсдэлээ  
тодорхойлох нь  
чухал!

## ДОТООД АУДИТЫН ТАЛААРХ ХАНДЛАГА

### Уламжлалт хандлага



Гүйлгээнд суурилсан



Данс бүртгэлд чиглэсэн



Нийцэл, даган мөрдөлтөнд чиглэсэн



Бодлого, процедурийг төвөө болгосон



Төсөвлөсөн зардалд анхаарсан



Арга зүй: Бодлого журам, ажил гүйлгээ, нийцэлд төвлөрсөн

### Орчин үеийн хандлага



Процесст суурилсан



Менежментэд чиглэсэн



**Эрсдэлийг илрүүлэх, процессыг сайжруулахад чиглэсэн**



Эрсдэлийн удирдлагыг төвөө болгосон



Гүйцэтгэлийг сайжруулахад анхаарсан



Арга зүй: Зорилго, стратеги, эрсдлийн удирдлагын процесст төвлөрсөн



## ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ



### Төсвийн тухай хуулийн 12.1.6:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;



### Төсвийн тухай хуулийн 14.1.15:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн;



### Төсвийн тухай хуулийн 14.1.17:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн

69.3. Дотоод аудитад **төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний** төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

## Шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчил



Худалдан авах ажиллагааны хууль, журмыг баримтлан ажилладаггүй.



Тодорхой хэрэгцээ шаардлага, баримт материал, гэрээ хэлцэлгүй бусдад мөнгө шилжүүлэн авлагад бичээд орхих, өр авлагыг хооронд нь хаах



Зээлийн барьцаа хөрөнгийн бүртгэл хангалтгүй.



Орлогыг бэлнээр хураан авч касст тушаалгүй зарцуулах.



Тооллого хийж тооцоо боддоггүй, балансын дүнтэй тооллогын бүртгэлийн дүн, бэлэн байгаа хөрөнгийн дүн тохирдоггүй



Хугацаа хэтэрсэн өр төлбөрийн барагдуулалт хангалтгүй.



ИТХ-с газрын төлбөрийг тогтоохдоо итгэлцүүрийг буруу хэрэглэж, нэгжийн өртгийг буруу тогтоох, гарсан тогтоолыг засварлах явдлыг таслан зогсоох

## САНХҮҮГИЙН ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН



Төсвийн  
төлөвлөлтийн  
алдаа



Төсөв захиран  
зарцуулагч,  
нягтлан бодогч,  
эд хариуцагч  
солигдох



Мэдлэг,  
боловсрол  
чадварын  
түвшин



хувийн ашиг  
сонирхол, ёс  
зүй



Дарамт  
шахалт

ХАМТЫН АЖИЛЛАГАА  
АМЖИЛТЫН ҮНДЭС!





МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА!**